



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗАР**

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа,

Утас/Факс: (976) 7013 3458,

И-мэйл: foreignrelations@immigration.gov.mn,

Вэбсайт: www.immigration.gov.mn

2021.06.10 № 01/830


танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН С.ЦЭДЭНДАМБА
ТАНАА

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн,
харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2021
оны эхний хагас жилийн тайланг хавсралтаар
хүргүүлэв.

ДАРГА

НҮҮГАНБАЯР




rest 10/10

d.v.

L. lyraeum

8. Adelodolus

Wolffsohn



Гадаадын иргэн харьяатын газрын
2021 оны 06 дугаар сарын ...-ны өдрийн
0//80 дугаар албан бичгийн хавсралт

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТАЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 2021 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийн хүрээнд нэгтгэн танилцуулж байна.

Зохион байгуулалтын хүрээнд:

Салбар зөвлөлийн хуралдааныг 2021 онд 3 удаа зохион байгуулж, дараах 5 асуудлыг хэлэлцэж, холбогдох тогтоол, чиглэлийг баталлаа. Үүнд:

- 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаар: салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, 2021 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлах;
- 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар: төрийн захиргааны албан хаагчдад төрийн алба хаасан хугацаа, тухайн албан тушаалын ангилалд ажилласан жил, 2020 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дүнг харгалзан эрхэлсэн болон дэс түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн албаны зөвлөлд тус тус уламжлах;
- 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар хуралдаанаар: төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах шалгалтын комисс байгуулах;

Салбар зөвлөл нь жилийн дүнгээр 10 тогтоол баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- Салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай 01 дүгээр тогтоол;
- Салбар зөвлөлийн гишүүдэд урамшуулалт олгох тухай 02 дугаар тогтоол;
- М.Эрдэнэсүрэнг Виз, зөвшөөрлийн газарт мэргэжилтнээр томилуулахаар нэр дэвшүүлэх тухай 03 дугаар тогтоол;
- Б.Тэлмэнг Виз, зөвшөөрлийн газарт мэргэжилтнээр томилуулахаар нэр дэвшүүлэх тухай 04 дүгээр тогтоол;

- Б.Гэрэлт-Одыг Зүүн бүс дэх газрын мэргэжилтнээр томилуулахаар нэр дэвшүүлэх тухай 05 дугаар тогтоол;
- А.Дөлгөөнтамирыг Зүүн бүс дэх газрын мэргэжилтнээр томилуулахаар нэр дэвшүүлэх тухай 06 дугаар тогтоол;
- Э.Мөнхгэрэлийг Хойд бүс дэх газрын мэргэжилтнээр томилуулахаар нэр дэвшүүлэх тухай 07 дугаар тогтоол;
- О.Өсөхбаярыг Хойд бүс дэх газрын мэргэжилтнээр томилуулахаар нэр дэвшүүлэх тухай 08 дугаар тогтоол;
- Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг дэмжих тухай 09 дүгээр тогтоол;
- Удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх шалгалтын комисс байгуулах тухай 10 дугаар тогтоол;

Салбар зөвлөлд 2021 оны эхний хагас жилийн дүнгээр Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн 4 тогтоол, 7 албан бичиг, явуулсан албан бичгийн тоо 10, үүнээс хариутай 1 албан бичгийг заасан хугацаанд бүрэн хүргүүлэв.

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх хүрээнд:

Байгууллагын зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн нэгдсэн систем дэх төвийн газрын 121 албан хаагчийн нэгжийн нэр, албан тушаалын нэр, ангилал, зэрэглэл, нэмэгдэл хөлсийг шинэчлэн бүртгэж, цалин хөлсний нягтлан бодогчтой тулгалт хийж мэдээллийг бүрдүүлсэн, цалингийн шатлал өөрчлөгдсөн төвийн газрын 33 албан хаагчийн мэдээллийг хүний нөөцийн нэгдсэн системд мэдээллийг шинэчлэн оруулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын заасны дагуу байгууллагын бүтэц зохион байгуулалттай холбоотой томилгооны тушаал, бусад тушаал шийдвэрийг нийт 270 албан хаагч хувийн хэрэгт 690 хуудас баяжилт хийж, цахим хувийн хэрэгт файлаар хавсаргав.

Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системийн ашиглалт, албан хаагчдын мэдээллийг оруулах, шинэчлэх ажлын явцад хяналт хийж, арга зүйн зөвлөмж, чиглэлээр хангах, хүний нөөцийн системийн болон төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системийн мэдээллийг үнэн зөв, баталгаатай байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргаар батлуулсан удирдамжийн дагуу орон нутаг дахь газруудад 05 дугаар сард багтаан түүврийн аргаар хяналт хийж байна. Шалгалтын дүнг үндэслэн хүний нөөцийн нэгдсэн системийн ашиглалт, мэдээллийн баяжилтыг сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлэх юм.

Төрийн албаны нөөц бүрдүүлэх хүрээнд:

Шинэчлэгдсэн Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн системийн нөөцийн бүртгэлд Өмнөд бүс дэх газрын ахлах мэргэжилтэн Г.Буянням, Санхүү, хангарт үйлчилгээний газрын дарга Б.Даваажав, Захиргаа, удирдлагын газрын хуулийн ахлах мэргэжилтэн М.Уранбилэг нарыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-д заасны дагуу бүртгэлээ.

Нөөцийн бүртгэлийг хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн системд тухай бүр оруулж, баяжилт хөдөлгөөнийг хийж хэвшсэн.

Маргаан хянан шалгах хүрээнд:

Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01/530 дугаар албан бичгээр ирүүлсэн “Хууль хэрэгжүүлэх тухай” чиглэл, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн “Мэдэгдэл”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нийтлэг удирдамж”-д заасан үүрэг даалгавар, зөвлөмж чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрх хэмжээнийхээ хүрээнд агентлагийн удирдлага болон төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгжээс төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагааны зөрчлийг арилгах зорилгоор агентлагийн хэмжээнд байгаа томилгооны өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай танилцуулгыг боловсруулж, 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр холбогдох удирдлагуудад танилцуулав.

Агентлагийн зохион байгуулалтын бүтцэд байгаа нийт 310 орон тооны 218 буюу 70.3 хувь нь төрийн захиргааны албан тушаал байгаагийн “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд хийсэн 21 албан тушаалын, 9.6 хувийг эзэлж байгаа томилгооны зөрчлийг арилгах ажлын хүрээнд сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.

Төрийн албаны шалгалт зохион байгуулах хүрээнд:

Эхний хагас жилийн дүнгээр 2020 онд зарлагдсан боловч сонгон шалгаруулалтаар нөхөгдөөгүй төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 6 сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр хүргүүлснээр Төрийн албаны зөвлөлөөс зарыг 02 дугаар сард “www.csc.gov.mn” цахим хаягаар болон байгууллагын “immigration.gov.mn” цахим хуудсаар нийтэд хүргэсэн.

Сонгон шалгаруулалтыг 03 дугаар сарын 05-ны өдөр 3 ээлжээр шалгалтыг зохион байгуулан нийт 18 иргэн оролцож, хамгийн өндөр оноо авч, тэнцсэн 6 иргэнийг тухайн албан тушаалд нэр дэвшиүүлж, 04 дүгээр сарын 08-ны өдөр 6 сарын туршилтын хугацаагаар томилсон.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр,

зохион байгуулалтын бүтэц"-ийн хүрээнд тус агентлагт зарим бүтцийн нэгж нэмэгдсэн, өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан төрийн захиргааны удирдах албан тушаалын 8, гүйцэтгэх албан тушаалын 16 сул орон тоог "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-д заасны дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас болон удирдах албан тушаалтын нөөцөд байгаа иргэдээс нөхөх сонгон шалгаруулалтын товыг тогтоож, нийтэд зарлуулах хүсэлтийг салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 07-ны өдрийн 07, 08 дугаар, 05 дугаар сарын 06-ны өдрийн 09, 10 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.

Төрийн захиргааны удирдах албан тушаалын 8, гүйцэтгэх албан тушаалын 16, нийт 24 сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах шалгалтын комиссыг салбар зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлаад байна.

Сургалт судалгаа, сурталчилгаа хийх хүрээнд:

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног тутам салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд болон хүний нөөцийн мэргэжилтнүүдийг 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр анх эхэлсэн, "Төрийн албаны зан үйлийн менежмент" цуврал вэбинаар, Пүрэв гарагийн 21 удаагийн цахим сургалтад хамруулж, 4 дүгээр сараас эхлэн орон нутаг дахь нэгжийн захиргааны ахлах, захиргааны мэргэжилтнүүдийг оролцуулж, мэдээллээр хангаж байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ" цахим сургалтад хамрагдаж, гэрчилгээ авах үүрэг, чиглэлийг төв болон орон нутгийн зохион байгуулалтын нэгжийн дарга нарт хүргүүлж, сургалтаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", мөн оны 216, 217, 218 дугаар тогтоолуудаар батлагдсан стратеги төлөвлөгөө, байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлагнах, үнэлэх журмуудыг судалсан бөгөөд нийт 42 албан хаагч хамрагдлаа.

Гадаадын иргэн, харьяатын газрын сургалтын 2021 оны төлөвлөгөө, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны "Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай" зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилт өхний хагас жилийн дунгээр 70 хувийн биелэлттэй.

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Хүрсэн түвшин /тоогоор/	
				Сургалт	Албан хаагч
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагын сургалтад хамруулсан байдал	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	14	230
			Ажлын байран дахь сургалт	11	198
			Захиалгат бусад сургалт	3	32
		1.2	Мэргэшүүлэх багц сургалт	5	11
			Чиглүүлэх богино хугацааны сургалт	0	0
			Мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	1	3

		Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт	1	5
		Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт	1	1
		Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт	1	1
		Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт	1	1
НИЙТ ДҮН			19	241

Төрийн албаны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан туурвиж, 2021 онд хэвлүүлсэн Төрийн албаны зөвлөлийн гишүүн, хууль зүйн ухааны доктор, профессор Д.Зүмбэрэлхамын “Төрийн алба: шинэтгэлд шимтэхийн учир” номыг агентлагийн удирдлага, төв болон орон нутаг дахь нэгжийн дарга нар, орон нутаг дахь газар, хэлтсийн захиргааны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн, хуулийн, тайлан төлөвлөгөө, тогтоол шийдвэр хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд нийт 35 ширхэг захиалан авах 1,225,0 мянган төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, холбогдох нэгж, албан хаагчдад тараалаа.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд:

Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, уг хуулиар 61 заалтад өөрчлөлт орсноор тус агентлагийн бүтэц, зохион байгуулалт, албан тушаалын хуваарилалтад өөрчлөлт орж, чиг үүрэг нэмэгдсэнтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан 310 орон тоонд үндэслэн агентлагийн зохион байгуулалтын нэгжүүдэд бүтцийн өөрчлөлт хийлзээ.

Бүтцийн өөрчлөлт хийхдээ дараах эрх зүйн болон төв, орон нутаг дахь нэгжүүдийн ажлын байрны зураг авалтын нэгдсэн дүн, ажлын байрны шинжилгээний санал дүгнэлтийг тус тус харгалзан үзсэн. Үүнд:

1.БНХАУ-ын Эрээн, Хөх хот, Манжуур, БНСУ-ын Сөүл хот дахь Дипломат төлөөлөгчийн газарт тус тус виз, зөвшөөрлийн чиглэлээр улсын байцаагч томилон ажиллуулах;

2.Цахим виз (evisa.mn) олгох эрх зүйн орчныг шинээр тусгаж, хил дээр олгодог цахим виз, визийн шинэ төрлийг бий болгох;

3.Хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Агаарын замын боомтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоол гаргаж, Улаанбаатар хотын “Бүянт-Ухаа” олон улсын нисэх буудал дахь агаарын замын хилийн боомтыг Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшгийн хөндийд байгуулагдсан “Чингис хаан олон улсын нисэх буудал”-д шилжүүлсэн;

Гадаадын иргэн, харьяатын газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан төвийн болон орон нутаг дахь нэгжийн албан хаагчдыг байгууллагын даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Б/47 дугаар тушаалаар ажлаас чөлөөлж, мөн өдрийн Б/48 дугаар тушаалаар зохион байгуулалтын нэгжийн ажил, албан тушаалын жагсаалт, албан тушаалын

тодорхойлолтод заасан чиг үүрэг, албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага туршлага, тухайн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг харгалзан албан хаагчдыг шинээр томиллоо.

Тус агентлагт өмнөх (2018 онд баталсан) бүтцээр төвд 4 газар (Захиргаа, удирдлагын, Виз, зөвшөөрөл, харьяатын, Хяналт шалгалтын, Санхүү, хангарт, үйлчилгээний)-тай, 3 хэлтэс (Эрх зүй, гадаад харилцааны, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн, Мэдээллийн технологийн)-тэй, орон нутагт 6 газар, 1 хэлтэстэй байсан бол 2021 оны бүтцээр төвд 4 газар, 5 хэлтэстэй, орон нутагт 6 газар 2 хэлтэс, агентлагийн хэмжээнд нийтдээ 10 газар, 7 хэлтэстэй болсон.

Агентлагийн төвийн 130, орон нутгийн 180, нийтдээ зохион байгуулалтын нэгжүүдэд орон тоо нэмээгүй бөгөөд 310 орон тоонд багтаан орон нутаг дахь газар, хэлтсийн сул орон тоог хасаж, Буянт-Ухаа дахь хэлтсийг шинээр байгуулсан.

Албан тушаалын ангилал, зэрэглэлийн өөрчлөлт:

Албан тушаалын ангилал, зэрэглэл	Төв		Орон нутаг		Өөрчлөлт
	2018 он	2021 он	2018 он	2021 он	
Агентлагийн удирдлага					
Газрын дарга	T3-11	4	4	6	=
Хэлтсийн дарга	T3-10	3	5	1	2
Хяналтын улсын ахлах байцаагч	T3-8	3	4	7	6
Ахлах мэргэжилтэн	T3-7	22	23	41	32
Хяналтын улсын байцаагч		13	15	75	79
Мэргэжилтэн	T3-6	38	39	1	1
Төрийн үйлчилгээний албан хаагч	TY-1-8	45	38	49	54
Дүн		130	130	180	180
					-

Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275, “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 276 дугаар тогтоолыг баримтлан агентлагт хийсэн бүтцийн өөрчлөлтөөр:

- ахлах түшмэлийн ангилалд хамаарах (хэлтсийн дарга) албан тушаал 4 байсныг 3-аар,
- дэс түшмэлийн ангилалд хамаарах (хяналтын улсын байцаагч) албан тушаал 88 байсныг 6-аар,
- дэс түшмэлийн ангилалд хамаарах (мэргэжилтэн) албан тушаал 39 байсныг 1-ээр тус тус нэмэгдүүлж, нийт төрийн захиргааны 10 албан хаагчийн ангилал, зэрэглэл ахиснаар албан тушаалын цалин, холбогдох нэмэгдэл хөлсийг шинэчлэн тогтоолоо.
- мөн төрийн үйлчилгээний гүйцэтгэх албан тушаалд хамаарах төсвийн ахлах мэргэжилтэн, худалдан авалт хариуцсан 2 ахлах мэргэжилтний орон тоог дэс түшмэлийн албан тушаалын ангилалд шилжүүлснээр албан тушаалын цалин, холбогдох нэмэгдэл хөлс ахилаа.

Албан хаагчдын томилгооны өөрчлөлт, хөдөлгөөн

Албан тушаалын өөрчлөлт	Төв	Орон нутаг	Нийт
Эрх зүйн байдал дээшилсэн			

Дэвшүүлэн томилсон	8	11	19
Ангилал, зэрэглэл ахисан	4	9	13
Хяналтын улсын байцаагчийн эрх шинээр олгож томилсон	1	2	3
Хяналтын улсын байцаагчийн эрхийг сэргээж томилсон	-	3	3
Шилжүүлэн томилсон	3	10	13
Шинээр бий болсон орон тоо	4	8	12
Нийт	20	43	63
Эрх зүйн байдал хөндөгдсөн			
Бууруулан томилсон	3	-	3
Орон тоо хасагдаж, чөлөөлөгдсөн	-	2	2
Нийт	3	2	5

Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд албан тушаалын ангилал, зэрэглэл ахисан, дэвшүүлэн томилсон, хяналтын улсын байцаагчийн эрх шинээр болон сэргээн олгосон, албан хаагчийн хүсэлтийг харгалзан шилжүүлэн томилсон нийт 63 албан хаагчаас 19 буюу 31.1 хувийг албан тушаал дэвшүүлж, 13 буюу 21.3 хувийн ангилал, зэрэглэлийг тус тус ахиулсан бол 6 буюу 14.2 хувьд хяналтын улсын байцаагчийн эрхийг шинээр болон сэргээн олгож, эрх зүйн байдлыг дээшлүүлсэн.

Орон нутаг дахь газрын захиргааны ахлах мэргэжилтний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, газрын дотоод ажил, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор архив-бичиг хэргийн эрхлэгчийн орон тоог газар тус бүрт 1, нийт 6 орон тоо шинээр нэмж, мөн орон нутаг дахь газрын жижүүр, сантехникч, цахилгаанчин гэсэн ажлын байрны гүйцэтгэх чиг үүрэг, ажлын ачааллыг тэнцвэржүүлж, албан тушаалын зэрэглэлийг TY-1 байсныг TY-3 болгож цалинг ахиулах арга хэмжээ авлаа.

Харин эрх зүйн байдал нь хөндөгдсөн 5 албан хаагчийн тухайд: Эрх зүй, гадаадын харилцааны хэлтэс татан буугдсан, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэс өөрчлөн байгуулагдсанаар 2 хэлтсийн дарга, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст боомт, орон нутгийн сүлжээ хариуцсан мэргэжилтний 1, Баруун бүс дэх газрын 4 жолоочийн орон тоог бууруулж, 2 орон тоог хассантай холбоотой юм.

Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд агентлагийн даргын 2021 оны А/29 дүгээр тушаалаар орон нутаг дахь нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, А/30 дугаар тушаалаар төвийн нэгжийн албан тушаалын жагсаалтыг тус тус шинэчлэн баталсан.

Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр чиг үүрэг, нэршилд өөрчлөлт орсон болон шинээр батлах удирдах 10, гүйцэтгэх 43, нийт 53 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 45, 72, 73, 74 дүгээр тогтоолоор тус тус батлах зөвшөөрлийг авсан.

Агентлагийн төв болон орон нутаг дахь газар, хэлтсийн төрийн үйлчилгээний албан тушаалын нийт 51 албан тушаалд хамаарах шинээр болон шинэчлэн батлах 14, нэгжийн нэршил болон албан тушаалын нэр өөрчлөгдсөн 9, нийт 23 ажлын байрны тодорхойлолтыг агентлагийн даргын 2021 оны А/48 дугаар тушаалаар батлууллаа.

Төрийн үйлчилгээний зарим ажлын байрны тодорхойлолтыг шинээр болон шинэчлэн батлах, өөрчлөлт оруулах дээрх тушаал батлагдсантай холбогдуулан

2019 оны А/345 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт архивын эрхлэгчийн, 2 дугаар хавсралт архивч-операторчийн, 7 дугаар хавсралт төсвийн ахлах мэргэжилтэн-эдийн засагчийн, 8, 9, 10 дугаар хавсралт нягтлан бодогчийн, 11 дүгээр хавсралт үйлчилгээ хариуцсан мэргэжилтний, 12 дугаар хавсралт худалдан авалт хариуцсан ахлах мэргэжилтний, 14, 15 дүгээр хавсралт нярвын ажлын байрны тодорхойлолтыг тус тус хүчингүй болсонд тооцлоо.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд агентлагийн бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан үйл ажиллагаа нь байгууллагын орон тоо нэмэгдүүлэлгүйгээр Хөшгийн хөндийн “Чингис хаан” олон улсын нисэх буудал шинээр ашиглалтад орохтой холбогдуулан шинээр Буянт-Ухаа дахь хэлтэс байгуулж, зарим газар, хэлтсийн орон тоог хасах шаардлага гарсан ч агентлагийн удирдлага, захиргаанаас албан хаагчдын эрх зүйн байдлыг хөндөхгүй байх тал дээр онцгой анхаарч ажилласаны үр дүнд нийт албан хаагчдын 78.1 хувийн эрх зүйн байдал хэвээр, 20.3 хувьд эрх зүйн байдал дээшилсэн, 1.6 хувьд эрх зүйн байдал хөндөгдсөн үр дүнтэй байна.

Мөн салбарын хууль тогтоомжид заасан чиг үүрэг, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилтын хүрээнд Баян-Өлгий аймаг дахь хэлтэст Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн шууд захирагчийн эрхийг шинээр олгож, нягтлан бодогч, нярав-бичиг хэргийн орон тоог нэмж баталснаар төсвийн хувьд бие даах боломжийг бүрдүүллээ.

Төрийн албаны тухай хуулийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу агентлагийн 2021-2024 онд хэрэгжүүлэх төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 5 бүлэг, 8 зүйлтэй, 4 үндсэн зорилтын хүрээнд 41 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, Даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн агентлагийн даргын 2021 оны А/62 дугаар тушаалаар баталсан.

Шинэчлэн боловсруулсан хөтөлбөр нь дараах онцлог, давуу талтай. Үүнд:

- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг хамтад нь тусгасан;
- Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны үйл ажиллагаанд “Эрдэм сургалт судалгааны хүрээлэн” төрийн бус байгууллагаас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн тайланд “албан хаагчдын ажил үүрэгтээ хандах хандлага, сэтгэл ханамж”-ийг тодорхойлох асуумж, ярилцлагын дүнтэй уялдуулан SWOT шинжилгээ хийсэн;
- Дунд хугацааны төлөвлөлтийн зарчим, өмнөх хөтөлбөрийн хэрэгжилт дуусаж, шинэчлэн батлах хөтөлбөрийн суурь түвшнийг тодорхойлохтой холбогдуулан хүний нөөцийн талаарх 2020 оны (албан хаагчдын нас, хүйс, мэргэжил боловсролын түвшин, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, амьжиргааны нөхцөл байдал, нийгмийн баталгааг хангах чиглэлээр олгосон дэмжлэг тусlamж, хөрөнгө оруулалт) судалгаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн нь хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг оновчтой тодорхойлох боломж олгосон;
- Хөтөлбөрийн явц, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинээр боловсруулж тусгасан;

- Хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл явцыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, холбогдох журмын дагуу тодорхой тусгасан.

Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2021-2024 онд үргэлжлэх бөгөөд хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг агентлагийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, “Төрийн албан хаагчийн сургалт”, “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах” арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангах замаар үр дунд хургэхээр төлөвлөсөн.

“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” нь төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилт, үйл ажиллагааг тодорхойлон хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд батлан хэрэгжүүлж байгаа З дахь хөтөлбөр бөгөөд Төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албаны сургалтын нэгдсэн тогтолцоо бий болж, төрийн албан хаагчдыг үе шаттайгаар сургаж, мэргэшүүлэх эрх зүйн орчин бүрдсэн, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай” зөвлөмжид тодорхой тусгагдсан нь төрийн захиргааны байгууллагын хувьд хуулиар хүлээсэн зорилт чиг үүрэг, үйл ажиллагааны онцлог, стратегид нийцүүлэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллах боломж бүрдсэнтэй холбогдуулан албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт сургалтын бодлого, үйл ажиллагааны зорилтыг нэгтгэн тусгасан.

Хөтөлбөрийн төсөлд хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх зорилгоор 4 зорилтын хүрээнд 24 шалгуур үзүүлэлтийг баримтлан суурь түвшнийг 2020 оны дүнгээр томъёолсон бол 2024 онд хүрэх түвшнийг шалгуур үзүүлэлтээс шалтгаалан өссөн дүнгээр болон гүйцэтгэлээр тус тус үнэлэхээр тусгасан нь орон нутаг дахь бүтцийн нэгжүүдийн биелэлтийг тайлагнах, хэрэгжилтийг үнэлэх үйл ажиллагааг илүү тодорхой, оновчтой болголоо.

Төрийн албаны тухай хуулийн 21.2.3-т заасны дагуу дэс түшмэлийн зэрэг дэв олгуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд, мөн хуулийн 21.2.2-т заасны дагуу эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг ахиулах саналыг Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлэхээр салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор дэмжлээ.

Журмын дагуу төрийн албан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан жил, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үнэлгээний багийн дүнг үндэслэн төв болон орон нутаг дахь газрын төрийн захиргааны 55 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгох саналыг 01/584 дугаар, 2 эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг ахиулах саналыг Төрийн албаны зөвлөлд салбар зөвлөлийн 08 дугаар албан бичгээр тус тус хургуулэв.

Эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 14 дүгээр зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 1, “Алтан гадас одон”-оор 4, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 4, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/43 дугаар тушаалаар Хууль зүйн албаны Тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр 1, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 4, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тушаалаар “Нягтлан бodoх бүртгэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр 1 нийт 15 албан хаагч шагнагдсан байна.

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан төрийн дээд одон, медаль болон салбарын шагналд нэр дэвшүүлэхээр олон жил үр бүтээлтэй ажилласан 2 албан хаагчийг төрийн дээд одон “Хөдөлмөрийн хүндэт медаль”, “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”-ээр 7, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 19, бусад салбарын шагналд 2 нийт 30 албан хаагчийн нэрийг дэвшүүлж, холбогдох материалыг бэлтгэн байгууллагын даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/729 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Тайлан мэдээлэл хүргүүлэх чиглэлээр:

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн холбогдох нэгжид дараах мэдээ, судалгааг хүргүүлсэн. Үүнд:

Төрийн албаны тухай хуулийн 13, 18, 26, 33, 44, 58, 61 дүгээр зүйл болон холбогдох 4 журам, Засгийн газрын 1 тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх санал, шийдлийн талаарх мэдээллийг нэгтгэн салбар зөвлөлийн даргын 03 дугаар сарын 29-ний өдрийн 05 дугаар албан бичгээр;

Төрийн захиргааны байгууллагуудын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч буй дэргэдэх болон харьяа байгууллагуудын нэгдсэн бүртгэлд шаардлагатай мэдээллийг салбар зөвлөлийн даргын 03 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар албан бичгээр;

Төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах удирдах албан тушаалтуудын мэргэшүүлэх багц сургалтын болон 2021 онд төрийн албанд анх томилогдсон албан хаагчдын судалгааг ирүүлсэн маягтаар нэгтгэж, агентлагийн даргын 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/726 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.

Аслига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд:

Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус боловсруулж, агентлагийн даргаар батлуулав. Дээрх 2 төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулсан.

Мөн төв, орон нутаг дахь нэгжийн дарга, захиргааны ахлах мэргэжилтнүүдэд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайланг 06, 12 дугаар

сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 71 албан хаагч, иргэний материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүллээ. Үүнд:

- Байгууллага хооронд шилжин томилогодох-1
- Нэгж хооронд шилжин томилогодох-28
- Байгууллага хооронд сэлгэн ажиллах-1
- Албан тушаалын дэвшин ажиллах-15
- Шинээр томилогодох-24
- Албан тушаалын ангилал ахисан-2

Дээрх албан хаагч, иргэний ашиг сонирхлын талаарх Авлигатай тэмцэх газрын зөрчилгүй дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргаж хэвшлээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын үр дүнг дээшлүүлэх, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилгоор хилийн боомтуудад үйл ажиллагаа явуулдаг орон нутаг дахь бусийн 6 газарт салбар хариуцсан эрх бүхий албан тушаалтнаар захиргааны ахлах мэргэжилтнүүдийг томилон ажиллуулахаар холбогдох хууль тогтоомжийн чиглэлээр судалж, агентлагийн удирдлагад илтгэх хуудсаар танилцуулсан.

Орон нутаг дахь газарт салбар хариуцсан эрх бүхий албан тушаалтнаар 6 захиргааны ахлах мэргэжилтнийг агентлагийн даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Б/139 дугаар тушаалаар томилж, 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/779 дүгээр албан бичгээр хариуцан ажиллах чиг үүргийн талаарх зөвлөмж, чиглэлийг хүргүүлэв.

--оо--